



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 11/303

Улаанбаатар хот

Г Хан-Уул дүүргийн Биеийн тамир спортын
хорооны эргэлтийн бус хөрөнгийг
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 10,000,000.00 (арван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг нийслэлийн ерөнхий боловсролын 161 дүгээр сургуульд хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн Биеийн тамир спортын хороо (Т.Уранчимэг)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн ерөнхий боловсролын 161 дүгээр сургууль (Б.Балжинням)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501105

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 10 дугаар сарын 15-ны
өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Биеийн тамир спортын хороо

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт- анд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл /2024-09-08/	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	нийт үнэ			
1	Дэвжээ /жүдо/	2016.12.31	сайн	ш	20	250,000	5,000,000.00	5,000,000.00		Нийслэлийн ерөнхий боловсролын 161 дүгээр сургууль
2	Татами /жүдо/	2016.12.32	сайн	ш	25	200,000	5,000,000.00	5,000,000.00	-	
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							10,000,000.00	10,000,000.00	-	